МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 09 өдөр Дугаар А/94 Мандалговь

Мал амьтны гоц халдварт өвчнөөс
урьдчилан сэргийлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

Нэг. Тус аймгийн Дэлгэрцогт, Адаацаг сумдад мал амьтны гоц халдварт "Шүлхий" өвчин гарч өвчлөл буурахгүй байгаа, мөн Булган, Өвөрхангай аймгуудын төвд энэ өвчин гарсантай холбогдуулан урьдчилан сэргийлэх зорилгоор Сайнцагаан сумын нутгаар дамжин өнгөрөх, орох гарах төв замд ариутгалын постыг 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн ажиллуулахыг Сайнцагаан сумын Засаг дарга /Р. Мөнхтогтох/-д үүрэг болгосугай

Хоёр. Ариутгалын пост ажилуулахад албаны дэмжлэг үзүүлж ажиллахыг Онцгой байдлын газар /дарга х/а Я. Алтанхундага/, Цагдаагийн газар /дарга х/а М. Ганбаатар/, Мэргэжлийн хяналтын газар /дарга Ш. Төрбат/ нарт, Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Ж. Мөнхчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

0200297